

## **“БОДЬ ДААТГАЛ” ХК-ИЙН ХЭ-ИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ХУРААНГУЙ ТЭМДЭГЛЭЛ**

2022 оны 04 сарын 12

Улаанбаатар хот

“Бодь Даатгал” ХК-ийн ХЭ-ийн ээлжит хурал 2022 оны 04-р сарын 12-ны өдрийн 11:00 цагаас Annual general meeting (bdsec.mn) Цахим хэлбэрээр болж, Хурлын даргаар Гүйцэтгэх захирал Б.Золбаяр, Андеррайтингийн газрын захирал Б.Хүдэртулга, Санхүү хөрөнгө оруулалтын газрын захирал Б.Тулга болон Одгэрэл, Даваасүрэн, Хараат бус гишүүн Б.Бүжинлхам, Б.Эрдэнэбат Тооллогын комиссын дарга Б.Тэмүүлэн тооллогын бүрэлдэхүүн, Нарийн бичгийн дарга Ө.Батчимэг нарын бүрэлдэхүүнтэй оролцов.

### **ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ :**

1. Бодь даатгал ХК-ийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;

### **ХЭЛЭЛЦСЭН НЬ:**

**Б.Золбаяр:** Хурлыг нээж үг хэлэн, Хурлын даргаар миний бие томилогдон ажиллаж байна. Хурлын дэгийг та бүхэнд танилцуулъя.

-Хурлын дэгийг баталсанаар танилцуулав.

-Хурлын хэлэлцэх асуудлыг танилцуулав.

Тооллогын комиссын дарга Б.Тэмүүлэн ирцийг танилцуулна уу?

**Б.Тэмүүлэн:** “Бодь Даатгал” ХК-ийн саналын эрхтэй нийт 208,279,103 ширхэг энгийн хувьцаа эзэмшиж 53 хувьцаа эзэмшигч оролцож, нийт саналын эрх бүхий 228,275,458 энгийн хувьцааны 91,24% болж байгааг хурлын дарга болон хуралд оролцогчдод мэдээлж байна. Компанийн тухай хуулийн 69.1, 69.2 – т, Компаний тухай хуулийн 3,14 заасны дагуу 91.24% хувьцаа эзэмшигч хуралд оролцож байгаа тул ХЭЭХ-г хүчин төгөлдөр гэж тооцсугай.

**Б.Золбаяр:** За баярлалаа. Хурлыг цааш үргэлжлүүлъя.

Бодь Даатгал ХК-нь 1995 оноос хойш 27 жил үйл ажиллагаагаа явуулж нийт хөрөнгө 44,7 т.б, 140 ажилтан, 26 салбар, 21 аймагт үйл ажиллагаагаа явуулж байна. Нийт хураамжаар зах зээлд 22 хувийг бүрдүүлж байна. Давхар даатгалын хураамжаар салбарынхаа 38 хувь буюу салбартаа тэргүүлдэг. Цэвэр хураамжийн орлогоор 13 хувь буюу 2021 оны байдлаар салбартаа 3-т орж байна. Байгууллагын үндсэн сегментийн хувьд байгууллагын даатгал, иргэдрүү чиглэсэн иргэдийн даатгал, орон нутаг гэсэн 3 борлуулалтын сегментээр ажиллаж байна.

Үйл ажиллагааны давуу тал бол 2021 оны хөтөлбөрүүдийн тэр тусмаа АЖД –г автоматжуулах үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. Ингэснээр даатгуулагчийн нөхөн төлбөрийг 10-15 мин дотор шийдвэрлэн нөхөн төлбөрийг тухайн дансанд хурдан шуурхай шилжүүлж ажиллаж байна. Үүнийг дагаад хүний оролцоотой ажил 50 хувиар буурч байна. Компаний гол орлогын эх үүсвэр бол даатгалын үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа, давхар даатгалын үйл ажиллагаанд тулгуурлаж байна. Д/д үйл ажиллагаагаар манай компани салбартаа тэргүүлэн, шимтгэлийн орлогоор салбарынхаа 50-с дээш хувийн орлогыг бүрдүүлдэг.

2019 онд ердийн даатгалын салбар 195 т.б-т хүрч байсан бол 2020 онд 200 т.б, 2021 онд 241,5 т.б буюу 21%-р өссөн үзүүлэлттэй байна. Ердийн даатгалын цэвэр хураамж бол 2021 онд өссөн боловч 2022 онд буурч харагдаж байна. Бодь Даатгал ХК-н нийт хураамжийн хувьд 2020-2021 онд 59% өссөн ба түүхэндаа анх удаа 50 т.б төгрөгөөс дээш хураамжийг бүрдүүлсэн. Энэ өсөлт д/д-н үйл ажиллагаа болон д/д-н хэлтэс байгуулагдаж томоохон хэлцлүүдийг амжилттай байгуулсаны үр дүн юм. Цэвэр хураамжийн хувьд 31%-н өсөлт үзүүлж өнгөрсөн 2020 оноос 14,7 т.б –с 19,2 т.б болж өсжээ. 2021 онд борлуулалтыг тэлэх төлөвлөгөө боловсруулж ажилласан. Цэвэр ашиг 2020-2021 онд 863,000,000 болж өмнөх жилийн ашгаас 55%-р буурсан үзүүлэлттэй байна. Урьдчилсан дүнгээр 2,3 т.б төгрөгийн ашигтай гарсан боловч BDO аудитын аудитлагдсан дүнгээр залруулга хийгдэж буурсан. 2021 оны зардал тооцсон нөхөн төлбөр 30 орчим хувиар өссөн, энэ нь олон хүчин зүйлээс болсон гол нөлөө нь инфляци өсөлтөөс үүсэж байна. Цаашдын төсөөллийн харицуулалтыг харж байна. Даатгалын үйл ажиллагаа үндсэн үйл ажиллагаанаасаа алдагдалтай гарсан байна. 2022 онд цэвэр хураамжийн орлогыг 2021 он хэрэгжүүлсэн тэлэлтийн төлөвлөгөөг үргэжлүүлж 24.1 тэрбум төгрөг буюу нийт цэвэр хураамжийн орлогын 26%-иар өсгөх төлөвлөгөөтэй байна. Давхар даатгалын шимтгэлийн орлого 2.5 тэрбум төгрөг, хүүгийн орлогийг 2.1 тэрбум төгрөг буюу нийт 6 тэрбум төгрөгний ашигтай ажиллах төлөвлөгөөтэй байна. Үүнээс төлбөрийн чадварын харьцаа 101.6%-д хүрсэнд нөлөөлсөн гол хүчин санхүүгийн зохицуулах хорооны төлбөрийн чадвар тооцохдоо хэвийн авлагын хязгаар тавьж давсан хэсгийг төлбөрийн чадварт тооцдоггүй нь нөлөөлсөн. Нийт цэвэр хөрөнгө буюу давхар даатгалтай холбоотой зардлуудаа хасаж 29.3 тэрбум төгрөгийн цэвэр хөрөнгө байна.

2021 оны үр дүнг хураангуй танилцуулвал цэвэр орлогын хураамжын төлөвлөгөө 91%-ийн гүйцэтгэлтэй, нийт хураамжын төлөвлөгөө 150%-ийн гүйцэтгэлтэй, нөхөн төлбөр 2 т.б-аас давсан ба сэлбэгийн инфляци, хураамжын өсөлттэй холбоотой төлбөр нэмэгдсэн. Инфляциас үүдэлтэй дундаж албан журмын даатгалын нөхөн төлбөр 400,000 байсан бол 700,000 төгрөг болж нэмэгдсэн. 2021 онд тэлэлтийн төлөвлөгөөгөө хэрэгжүүлэхэд түрээс, маркетингийн зардал хэтэрсэн нь зорилтот ашигт хүрээгүй. Хураангуй танилцууллаа.

2022 онд бол Ковидын нөлөө харьцангуй намжина гэж үзсэн. Инфляцийн нөлөө бол таамаглахад нилээн хүнд байна. Эдийн засгийн тодорхойгүй байдал үргэлжилж байна. Хэдийгээр ковидын нөлөө багассан ч гэсэн бусад улс оронд өрнөж байгаа дайны байдал нь эдийн засгийн асуудал, хил гаалийн тогтворгүй байдал үнийн өсөлтөд нөлөөлөхөөр байна.

2022 онд компанийн нийт ажилчдын орон тоо 30-40 хүний орон тоо буурч байгаа. Өнөөдрийн байдлаар 29 орчим орон тоогоор бууран үйл ажиллагаагаа үргэлжлүүлж байна. Бодь даатгал 3 газар оффис түрээслэн үйл ажиллагаа явуулдаг байсан бол 2 газраа болиод нэг оффист төвлөрч түрээсийн зардлаа 400 орчим м2-аар бууруулсан.

2022 оны санхүүгийн гол зорилтууд бол хураамжийн өсөлт 27%, хохирлын харьцаа 45%, зуучлалын зардлыг 15%, үйл ажиллагааны зардлыг 30%, даатгалын үйл ажиллагаанаас 10%-ийн ашигтай, цэвэр ашгийг 6 тб-д хүрнэ гэсэн маш тодорхой санхүүгийн зорилтуудыг тавьж байна.

Хурлын дэгийн дагуу 2021 оны ТУЗ- с гаргасан санхүүгийн дүгнэлтийг хэлэлцэн батлах байгаа / уншиж танилцуулав./

Компанийн цэвэр ашиг салбарынхаа 4.17%-ийг эзэлж байна.(өмнөх оныхоос -6.8%)

ТУЗ-ын зүгээс компанийн цэвэр ашиг 0.86 т.б төгрөг гарсан нь компанийг зорилтот ашигтаа хүрээгүй дунд түвшинд ажилласан гэж дүгнэж байна.

Хувьцаа эзэмшигчдийн асуулт хариулт санал хэлэх үйл ажиллагаа дуусч санал хэрхэн өгөх зааварчилгааг өгөн санал хураах үйл ажиллагаа эхлэв.

**Тооллогын комиссын дарга Б.Тэмүүлэн тооллогын шийдвэрийг танилцуулав.**

1. Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 99.98% буюу 208,247,630.00 ширхэг хувьцаатай 43 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар хүчинтэй санал өгсөн.

Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 99.98% зөвшөөрсөн, 0% татгалзсан, 0% түдгэлзсэн байна.

| Зөвшөөрсөн     |        | Татгалзсан |      | Түдгэлзсэн |      |
|----------------|--------|------------|------|------------|------|
| Тоо            | Хувь   | Тоо        | Хувь | Тоо        | хувь |
| 208,247,630.00 | 99.98% | 0          | 0%   | 0          | 0%   |

### **ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:**

1. Бодь даатгал ХК-ийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг Хавсралт №1-т заасны дагуу батлах,

Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарсан тогтоолын шийдвэрийг ТУЗ-н нарийн бичгийн дарга танилцуулан 12:20 минутад өндөрлөн хурлын дарга хурлыг хаав.

Хурлын дарга :

Б.Золбаяр

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

Ө.Батчимэг

